



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/24

Чингис хот

Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 32 дугаар зүйлийн 32.1.10 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолын хавсралт “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Хэрлэн сумын 2025 оны Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Г.Лхагвабаатар – сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Ж.Алтантөгс - Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Д.Буянбат – Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Сандагдорж – Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн
Л.Будсүрэн – Сургалт, сурталчилгаа, дотоод сүлжээ хариуцсан ажилтан

А.Алимаа – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Э.Золбаяр – Барилга, дэд бүтэц хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

М.Номинцэцэг – Гадаад харилцаа, аялал жуулчлал, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

Г.Мягмарсайхан – Булаг багийн зохион байгуулагч

2.Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг үнэн бодитой хийж, тайлагнаж ажиллахыг Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний дарга (Г.Лхагвабаатар)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР